



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/75

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын тусгай үйлчилгээний албаны тусгай зориулалтын автомашин, механизмын троссон шүүр, плугны резин, агаарын хөлгийн хөдөлгүүр халаагчийн хоолой нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	С.Нацагдорж	Газрын тусгай үйлчилгээний албаны дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Санчир	Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	Ц.Уянга	Газрын тусгай үйлчилгээний албаны чанар баталгаажуулалтын инженер
	С.Чинзориг	Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл
	Б.Энх-Амгалан	Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл

2. Нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /С.Нацагдорж/-нд даалгасугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, Тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Б.Санчир/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.БЯМБАСҮРЭН